

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН НУТАГТ ОРШИХ “АГАРТА РЕСОРТ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар № **5514231**/

Боловсруулсан: “Агарта ресорт вилла” ХХК-ийн

Байгаль орчны ажилтан.....Д.Хуягбаатар



УЛААНБААТАР 2025 ОН

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3-5
1.1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага.....	3
1.2. Төслийн байршил.....	3
1.3. Хүчин чадал.....	3
1.4. Ажиллах хүч.....	3
1.5. Барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг.....	3
1.6. Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал.....	3-4
1.7. Дэд бүтэц.....	4-5
1.7.1. Цахилгаан хангамж.....	4
1.7.2. Цэвэр усны хэрэглээ.....	4-5
2. ТӨСЛИЙН 2025 ОНЫ БОМТ-НИЙ БҮТЭЦ, ТӨСӨВ.....	5
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	6-9
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
4.1. БОМТ-ний гол зорилт, хамрах хүрээ.....	10
4.2. БОХТ, ОХШХ-ийн зардлын хураангуй.....	10
4.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	10-11
2. Газар, хөрсний эвдрэл, нөхөн сэргээлт, бохирдлоос хамгаалах төлөвлөгөө.....	12-13
3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	13
4. Хог хаягдлыг бууруулах, байгаль орчинд хог хаягдал гаргахгүй байх төлөвлөгөө.....	13-14
5. Болзошгүй осол эрсдлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө.....	15
4.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	15-16
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
10. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ.....	18
11. ЗӨВЛӨМЖҮҮД.....	19-20
11.1. Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах зөвлөмж.....	19
11.2. “ТХГН-ийн тухай” хуулийн дагуу хориглох зүйлс.....	19-20
11.3. Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд хориглох зүйлс.....	20
ХАВСРАЛТ.....	21

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1. **Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:** “Агарт ресорт вилла” ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар: 9011305057
 - Регистрийн дугаар: 5514231
- 1.2. **Төслийн байршил:** Хөвсгөл аймгийн Ханх сум, Анжигасын ам
- 1.3. **Хүчин чадал:** Жил 6-р сарын 25-аас 9-р сарын 25 хүртэлх хугацаанд үйл ажиллагаа явуулдаг ба нэг ээлжинд 40-60 амрагч хүлээн авах хүчин чадалтай.
- 1.4. **Ажиллах хүч:** Эрхлэгч, тогооч, үйлчлэгч, харуул, жолооч зэрэг ажил эрхэлдэг 30 ажилчинтай.
- 1.5. **Барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг:** Аялал жуулчлалын бааз нь дараах байгууламжуудаас бүрдэнэ.
 - Тансаг зэрэглэлийн хаус 4 ш
 - Студио хаус 10 ш
 - Люкс гэр 12 ш, хагас люкс гэр 8 ш
 - Ресторан, лоунж, задгай талбай террас.
 - Алжаал тайлах төв
 - Спорт талбай, тоглоомын өрөө
 - Ажилчдын байр, цайны газар
 - Угаалга, бие засах газар
 - Авто болон завины зогсоол зэргээс бүрдэнэ.
- 1.6. **Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал:** Аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдал гарна.
Хатуу хог хаягдал: Баазын үйл ажиллагаанаас цаас, хуванцар сав, гялгар уут, хоол хүнсний хаягдал зэрэг хаягдлууд гарах бөгөөд нийт ажиллах хугацаанд 2.5 тн хатуу хог хаягдал гарахаар БОННУ-д тооцсон.
Шингэн хаягдал: Нийт ажиллах хугацаанд 360 тн усыг унд ахуйн зориулалтаар хэрэглэх бөгөөд түүний 70% буюу 250 тн цэвэршүүлсэн бохир ус буюу /саарал ус/ гарна.

“Агарт ресорт” АЖБ нь Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд 14.8 га талбайд оршино.

“Мөнх Эрин Трэвел” ХХК нь 2013 оноос Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт байрлах Анжигансын аманд “Агарт” ресортыг байгуулсан. 2023 онд тус компанийн хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр компанийн нэрийг “Агарт ресорт вилла” болгон өөрчилсөн. Энэхүү шийдвэрийг ААН-н гэрчилгээний хамт хавсралт хэсэг оруулав.

Тус ресорт нь 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр эхний үйлчлүүлэгчдээ хүлээн авч, албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн Олон улсын чанарын жишигт хүрсэн эко бааз болох эрхэм зорилгодоо хүрэхийн тулд Экотуризмын тулгуур зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж “Байгальд ээлтэй, Соёлтой үйлчилгээ, Тав тухтай орчин, Тогтвортой байдал” уриаг удиртгал болгон ажиллаж байна.



Зураг 1, 2. Жуулчдын баазын ерөнхий байдал

1.7. Дэд бүтэц

1.7.1. Цахилгаан: Нар, салхины сэргээгдэх эрчим хүч болон цахилгаан үүсгүүрээр өөрийн эрчим хүчний хэрэгцээгээ хангана. Гэр ресторан, сауны барилга, баазын экохаус болон амрагчдын гэрүүд нь бүгд наран тал руу харсан шилэн хийцтэй учир өдрийн цагт нарны илчээр халахаар тооцож төлөвлөсөн. Үүн дээр нэмээд объектүүдэд цахилгаан халаагууруудыг суурилуулж өгсөн ба шаардлагатай үед ажиллуулна. Анжигасын амны байрлал нь энгэр дагуу байрлалтай бөгөөд тогтмол сэвэлзсэн салхитай байдаг онцлог нь сэргээгдэх эрчим хүч ашиглах таатай нөхцөл байдлыг бүрдүүлж байгаа учраас Төслийн хүрээнд хэрэглэгдэх ахуйн хэрэглээний эрчим хүчийг нарны болон салхины сэргээгдэх эрчим хүч ашиглан шийдвэрлэнэ. Харин тус баазын байрлал нь эрчим хүчний хувьд нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байдаг ба төслийн хүрээнд, шаардагдах өндөр чадлын эрчим хүчний хэрэгцээгээ дизель генератор ашиглан хангаж байна.

1.7.2. Цэвэр усны хэрэглээ: Жуулчны бааз байршиж буй газар нь налуу байрлалтай учраас үйлчилгээний байгууламжийг сантехникийн холболтод холбох боломжтой юм. Өөрөөр хэлбэл бааз байгуулах газрын гадаргын дээд талд усан санг, гадаргын доод талд бохир ус цуглуулах савыг тус тус суурилуулж Хөвсгөл нуураас насосоор усан санд ус татаж тэндээс байгууламжуудад түгээх, хэрэглэгдсэн хаягдал бохир усаа цуглуулах битүүмжилсэн саванд цуглуулдаг. Агарта резортод одоогийн байдлаар “Урал” маркын 3ш машин 2020 онд Агарта резортоос шингэн бохирыг Ханх сумруу тээвэрлэж байсан ба 2021 оноос эхлэн Хатгал Цахим ОНӨААТҮГ-тэй хамтран ажиллах гэрээтэй Хатгал тосгонруу тээвэрлэж байсан.

2022 оноос Герман улсын GRAF брэндийн бохир ус цэвэршүүлэх байгууламжын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж ашиглалтад оруулаад байгаа бөгөөд бохир усыг

Монгол улсын MNS 4943 : 2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх бохир усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэршүүлж байна.

Байгалийн усыг зохистой, хэмнэлттэй ашиглах зарчмыг хэрэгжүүлж, аялал жуулчлалын баазын бүх угаалтуур, шүршүүр, гоожуурт автомат мэдрэгчтэй тоног төхөөрөмжийг суурилуулж байнгын ажиллагаатай байлгаж байна. Ахуйн хэрэглээнээс ялгарсан бохир усыг дахин цэвэршүүлж ариун цэврийн угаалга, жорлон, зүлэг услах зэрэгт дахин ашиглана.

2. Төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт төсөв

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөр багтсан. Байгаль хамгаалах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг багтаасан бөгөөд хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө мөн тусгагдсан.

БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор шаардлагатай авч хэрэгжүүлэх арга хэмжээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт мөн тусгалаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **8,285,000** төгрөг төсөвлөсөн бөгөөд үүнд байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх болон хог хаягдлыг зайлуулах төсөв, шаардлагатай шинжилгээнүүдийн мөнгөн дүнг тооцсон.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь улирлын онцлогоос ихээхэн хамааралтай бөгөөд ТХГН болон байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн явагддаг тул байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг. Энэхүү аялал жуулчлалын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2014 онд анх хийлгэсэн ба 2021 онд “Ашид ананд” ХХК-аар нэмэлт тодотгол хийлгэж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Эко жуулчны бааз байгуулах төслөөс байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, түүний эрчимшил зэргийг магадлан жагсааж, болзошгүй нөлөөллийг тодрууллаа.

Хүснэгт 1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	шууд	шууд бус	өөрөө зохицуулагдах	богино хугацааны	урт хугацааны	буцаж нөлөөлөх	буцалтгүй нөлөөлөх	хүчтэй	дунд зэрэг	бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
Газрын доорх усны чанарын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x			x
Геологийн тогтоцын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x		x	
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	x				x		x			x
Бэлчээрийн байдал	x				x		x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц	Нөлөөлөл байхгүй									
Эрчим хүчний нөөц	Нөлөөлөл байхгүй									

3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	Нөлөөлөл байхгүй									
Урсгал усны хэрэгцээ	Нөлөөлөл байхгүй									
Агаарын бохирдол	Нөлөөлөл байхгүй									
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Дуу чимээ, шуугианы нөлөө	Нөлөөлөл байхгүй									
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	Нөлөөлөл байхгүй									
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	Нөлөөлөл байхгүй									
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	x				x					x
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		x		x		x				x
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x			x			x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
6. Эдийн засаг										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x	x			x	
Татварын орлого өөрчлөгдөх	x				x	x			x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x					x

Ажлын байр нэмэгдэх	X				x		x			x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X				x		x		x	
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, авто машины хөдөлгөөний нөлөөллөөс хөрс эвдрэх	x				x		x		x	
Ахуйн бохир уснаас хөрс бохирдох	x				x		x		x	
Хог хаягдлаар хөрс, ус бохирдох	x				x		x		x	
Шатахуун, түлшний алдагдлаар хөрс, ус бохирдох	x				x		x		x	
Дүн	19	1	0	2	16	3	12	0	11	7

Шууд нөлөөлөл: Болзошгүй нөлөөллийн 19 (95%) шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Эко жуулчны бааз байгуулах, төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, усны бохирдол зэрэг хүрээлэн буй орчин, байгалийн орчны төлөв байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Шууд бус нөлөөлөл: Эко жуулчны бааз байгуулах төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 1 (5%) нь үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд шууд бусаар нөлөөлөхөөр байна.

Богино хугацааны нөлөөлөл: Аялал жуулчлалын газар нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг учраас үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх, хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх зэрэг нь богино хугацааны өөрчлөлтөд орно. Нийт нөлөөллийн 2 (11.1%) нь богино хугацааны нөлөөлөлд орж байна.

Урт хугацааны нөлөөлөл: Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн 16 (88.9%) нь урт хугацааны нөлөөлөл бөгөөд эко жуулчны бааз төслөөс ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрс, ус бохирдох зэрэг нөлөөлөл орж байна. Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үед байгалийн унаган төрхийг алдагдуулан, хөрс, ургамлын бүтцийг өөрчлөлт, элэгдэл эвдрэлд оруулах, ус, хөрс бохирдуулах зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах шаардлагатай.

Нөлөөллийн эрчим: Төсөл хэрэгжих орчны байгаль орчинд тухайн төслөөс байгаль орчинд хүчтэй нөлөөлөх нөлөөлөл бага бөгөөд талбайн болон түүний орчны хөрс, ургамлын элэгдэл, байгалийн үзэсг

элэнт өнгө төрх өөрчлөгдөх, хөрс, усны бохирдол зэрэг дунд зэргийн эрчимтэй нөлөөлөл ихтэй юм. Бага зэргийн эрчимтэй нөлөөлөлд тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх, хөрсний элэгдэл эвдрэл гэх мэт сөрөг, хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх, ажлын байр нэмэгдэх гэх мэт эерэг нөлөөлөлд хамаарч байна. Нийт 18 нөлөөллөөс 11 дунд зэргийн, 7 бага зэргийн нөлөөлөл байна. Нөлөөллийн эрчим Төсөл хэрэгжих орчны байгаль орчинд тухайн төслөөс байгаль орчинд хүчтэй нөлөөлөх нөлөөлөл бага бөгөөд талбайн болон түүний орчны хөрс,

ургамлын элэгдэл, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх, хөрс, усны бохирдол зэрэг дунд зэргийн эрчимтэй нөлөөлөл ихтэй юм. Бага зэргийн эрчимтэй нөлөөлөлд тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх, хөрсний элэгдэл эвдрэл гэх мэт сөрөг, хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх, ажлын байр нэмэгдэх гэх мэт эерэг нөлөөлөлд хамаарч байна. Нийт 18 нөлөөллөөс 11 дунд зэргийн, 7 бага зэргийн нөлөөлөл байна.

-Хог хаягдал: Тухайн төслөөс амрагч, аялагчдын эргэн тойронд аялах, зугаалах үед үүсэх хог хаягдал, амралтын газрын үйл ажиллагаанаас гарах хатуу болон шингэн хог хаягдал нь амралтын газрын орчин тойрны хөрс, усыг бохирдуулах магадлалтай. Иймээс хог хаягдлын менежментийн зөв зохистой явуулах талаар анхаарч ажиллах нь зүйтэй.

-Хаягдал бохир ус: Эко жуулчны бааз, амралтын газар байгуулах төслийн байгаль орчинд учруулж болох гол сөрөг нөлөөллүүдийн нэг нь шингэн хог хаягдлын аюулгүй ажиллагаа, битүүмжлэл алдагдаж болзошгүй явдал бөгөөд дэлгэрэнгүйг ахуйн шингэн хог хаягдлын менежментэд орууллаа.

-Ургамалан бүрхэвчийн доройтол: Хөвсгөл аймгийн Ханх сумын нутаг дахь Хөвсгөл нуурын зүүн эрэг байгалийн унаган төрхөө харьцангуй онгоноороо хадгалж үлдсэн, ургамлан нөмрөгийн хувьд хүний үйл ажиллагааны нөлөө бага байсан учраас төслийн үндсэн үйл ажиллагаанаас ургамлын бүрхүүлд нөлөөлөх нөлөөлөл их юм. Ялангуяа жуулчны баазын үйл ажиллагаанаас машин техникийн шилжилт хөдөлгөөн амрагч, аялагчдын маршрут болон жуулчны баазын барилга байгууламж барих үйл ажиллагаанаас тус талбайн ургамлан нөмрөгийг доройтолд хүргэж болзошгүй юм.

-Хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл: Жуулчны баазын барилга байгууламж барих, үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх явцад амрагчид, техникийн нөлөөгөөр ургамал гэмтэх, устах, хөрс эвдрэлд орохоос гадна нефтийн бүтээгдэхүүн, хатуу ба шингэн хог хаягдлаас болж хөрсөнд бохирдол үүсч болзошгүй.

-Усны бохирдол: Тухайн төслөөс усан орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл нь амрагч аялагчдын аяллын маршрутын дагуух усан замаар аялах үед хог хаягдлыг усанд алдах, хаях, жуулчны баазын ахуйн хатуу болон шингэн хаягдлыг ус руу оруулах, аялагч амрагчид гоо сайхны болон угаалгын бодисыг ус руу оруулж усан орчныг бохирдуулах аюул учирч болзошгүй.

Тиймээс усан замаар зорчиход хог хаяхгүй байх талаар аялагчдад чиглэсэн зөвлөмж анхааруулгыг өгч түүнд хяналт тавин аюулгүй зорчуулах байдлыг хангаж ажиллавал зохино. Мөн жуулчны бааз орчимд Анжигасын гол болон Хөвсгөл нуурт ус бохирдуулагч бодис болон хог хаягдал оруулахгүй байх тал дээр анхаарч хяналт тавин ажиллах нь зүйтэй.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Байгаль хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт нь төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн

үр дагаврыг хянах үүрэгтэй. Энэ бүлэгт БОАЖЯ-ны сайдын 2019.10.29 өдрийн А-618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Хөвсгөл аймаг болон Ханх сумын орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны албан хаагч, Төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага, олон нийт хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх үүрэг, хариуцлагыг "Агарт ресорт" эко жуулчны бааз, амралтын газар хүлээнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөн, шаардагдах зардлын хэмжээг төсөвлөв.

4.2. Байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Хүснэгт 2. БОМТ зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал (төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,200,000
2		Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,500,000
3		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	500,000
4		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,150,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,935,000
Нийт зардал			8,285,000

4.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

4.3.1. Агаарын бохирдол, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

-Нөлөөллийн товч тодорхойлолт

Төсөл хэрэгжих явцад ашиглагдах машин техник, бусад шаталтат хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл, дизель хөдөлгүүрээс хорт хий \CO, CO₂, NO₂ зэрэг\ ялгарах, шатахуун, тосолгооны материалын агуулах, хадгалах савны битүүмжлэл алдагдах болон цэнэглэх, засвар үйлчилгээний хийх үед шатахуун уурших, асгарч болзошгүй.

Үйлчилгээний болон аялагч зорчигчдын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас зарим тодорхой нөхцөлд (хур тунадас орохгүй удах, авто машины замын нөхцөл зэргээс хамаараад) тоос агаарт дэгдэнэ.

Гэнэтийн осол тухайлбал, түймэр, галын аюулын үед олон төрлийн хортой хийнүүд үүсч байгаль орчныг бохирдуулах магадлалтай.

-Нөлөөлөлд өртөх объект

Амрагч, аялагчид, ажиллагсад болон тээврийн хэрэгслийн жолооч, ачигч болон ойр оршин суугчдын эрүүл мэндэд нөлөөлнө.

Хүснэгт 3. Агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах хяналт, үзлэг хийх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ Сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Машин, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тоос, шороо босох	Тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх, чийглэх, хөдөлгөөнийг зохицуулах	Жуулчны баазын талбай, эргэн тойрны бүсийг хамруулна.	0.5	шаардлагатай үед	“Байгаль орчныг хамгаалах тухай” хууль
Машин, техник, дизель станцын хөдөлгүүрээс ялгарах хорт хий	Хөдөлгүүрээс үүсэх хорт хийн хяналт, техникийн үзлэг	Машин техникийн бүрэн байдлын үзлэг, шата-хууны хэмнэлт-тэй хэрэг-лээний горим нэвтрүүлэх	0.2	жилд 2 удаа	Зөвшөөрөгдөх хэмжээний стандарт \Агаарын чанарын MNS 4585-98, MNS 42\
Зорчигчдын ирж, буцах автозамын дагуу босох шороо, тоос, бохирдол зэрэг сөрөг нөлөө үүсэх	Зорчигч, аялагчдын ирэх, буцах автозамын тоос, шороог багасгах, бохирдол, сөрөг үр дагавар үүсэхээс сэргийлэх хяналт	Амрагч, зорчигчдын ирэх, буцах авто замын дагуу	0.5	Жилд 2 удаа	“Агаарын тухай” хууль
Дүн:			1.2		

4.3.2. Газар, хөрсний эвдрэл, доройтлын нөхөн сэргээлт, бохирдолоос хамгаалах төлөвлөгөө.

-Нөлөөллийн товч тодорхойлолт

Тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад төслийн талбай орчмын газрын гадарга, хөрсөнд үүсэх эвдрэл, доройтол, үржил шим тодорхой хэмжээгээр алдагдах нөхцөл бүрдэнэ.

-Нөлөөлөлд өртөх объект.

Жуулчлалын бааз, амралтын газрын ашиглалтад хамрагдах хөрс шууд нөлөөлөлд өртөнө.

Хүснэгт 4.Газар, хөрсний эвдрэл, доройтлын нөхөн сэргээлт, бохирдолоос хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Барилга, байгууламж, шинэ объект барих, амрагч, аялагч, ажиллагсдын хөдөлгөөнөөс амралтын ашиглалтын талбайд хөрс, ой, ургамалд сөрөг нөлөөлөх	Жуулчны бааз, амралтын газрын орчимд ногоон байгууламж барих, моджуулах, зүлэгжүүлэх	Амралтын газрын ургамлан бүрхэвч доройтсон 3 га талбайг хамруулах	1,0	Жилд 1 удаа	“Байгаль орчныг хамгаалах” тухай хууль
Амрагч, аялагчдын аялалын зам, чиглэлийн дагуу хөрс, ургамалд сөрөг нөлөөлөл үүсэх	Амрагч, аялагчдын ой мод, уул, далайн хөвөөгөөр аялах зам, чиглэлийн дагуу тохижилт хийх	Аялалын зам, чиглэлийг тодорхой болгож хаягжуулах, сурталчилгааны самбар, эко шошго тэмдэгжүүлэлт байршуулах, харуул хамгаалалтын хяналтын системтэй болох	0.5	байнга	
Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын дэглэм зөрчигдөх	Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын дэглэм, хориглох үйл ажиллагааны тухай хууль, тогтоомж, журмыг сурталчилан таниулах, хэрэгжүүлэх	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, ялангуяа байгалийн цогцолборт газрын хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэх хүрээнд	Шаардахгүй	байнга	ТХГН-ийн тухай хууль
Аялагч, зорчигч, жуулчны баазын машин, техник, тийрэлтэт завь, шатахууны агуулах сав, дизель станцаас бензин, шатахуун, тос, тосолгооны материал хөрсөнд нэвчих, усанд орж бохирдуулж болзошгүй	Машины зогсоол, машин угаах, засварлах газар, шатахууны агуулах сав, дизель станц, завины зогсоол зэрэг бензин, дизелийн түлш, тос, тосолгооны материал асгарч, гоожих зэргээр хөрсөнд нэвчих, ус бохирдуулах	Бензин, дизелийн түлш, тос, тосолгооны материал зэрэг бохирдуулах бодис хөрсөнд нэвчих, усанд орж болзошгүй бүх цэг, байршилд	0.5		

	аас хамгаалж дэвсгэр бүрхүүл хийх ажлыг зохион байгуулах				
Дүн:			2.0		

4.3.3. Усны бохирдлоос хамгаалах төлөвлөгөө.

-Нөлөөллийн товч тодорхойлолт:

Төслийн үйл ажиллагааны явцад усан орчин ямар нэгэн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй.

-Нөлөөлөлд өртөх объект:

Усан орчныг бохирдлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх амрагч, аялагчид болон ажиллагсдын гол анхаарах гол объект мөн.

Хүснэгт 5. Усны бохирдолоос хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ.

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая. Төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Далайн эргээр аялах, зугаалах, усанд шумбах, сэлэх үеийн сөрөг нөлөөлөл	Далайн усанд сэлэх, шумбах, далайн эргээр аялагчид усанд ямар нэгэн бохирдол оруулахгүй байх сурталчилгаа байнгын харуул хяналт тавих, хяналтын камер байршуулах	Амралтын газрын баруун эргийн эргэн тойрныг бүрэн хамруулна. Анжигасын голын дагуух байршилд.	1.0	байнга	“Усны тухай” хууль
Дүн:			1.0		

4.3.4. Хог хаягдлыг бууруулах, байгаль орчинд хог хаягдал гаргахгүй байх төлөвлөгөө:

-Нөлөөллийн товч тодорхойлолт:

Ахуйн хатуу, шингэн хог хаягдал, машин техникийн шатах тослох материал, бусад хаягдлаас орчны ус, хөрс бохирдоно. Түүнчлэн хүнсний сав баглаа боодол, гоо сайхны жижиг сав, саван, угаалгын шингэний үлдэгдэл амралтын газрын орчинд хаягдах өндөр магадлалтай.

-Нөлөөлөлд өртөх объект:

Орчны ус, хөрс, ургамалын бүрхэвчид шууд нөлөөлнө.

Хүснэгт 6. Хог хаягдлыг бууруулах, тэдгээрийн бохирдолоос хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг жилд	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Амрагч, аялагчдын эргэн тойронд аялах, зугаалах үед үүсэх хог хаягдал	Жуулчны баазын байршилд болон ой мод, уул, далайн эргээр явах үед хог хаягдал гаргахгүй байх хяналт, хоггүй байлгах арга хэмжээ	Амрагч, аялагчдын явах, зугаалах бүх талбайг хамрах	0.5	байнга	Хог хаягдлын тухай хууль
Амралтын газрын хатуу хог хаягдлын сөрөг нөлөөлөл	Амралтын газрын хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт	Хатуу хог хаягдлын хөрөнгө оруултыг жил жилийн төлөвлөгөөнд тусгах учир энд оруулсангүй	-	байнга	Хог хаягдлын тухай хууль
Шингэн хог хаягдлын аюулгүй ажиллагаа, битүүмжлэл алдагдаж болзошгүй	Шингэн бохирын хаягдлыг халих, шүүрэхээс найдвартай хамгаалах менежментийн үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт	Шингэн бохирыг зориулалтын машинаар соруулан зөөвөрлөж байгаа. Энэ онд цэвэршүүлэх байгууламж барих бөгөөд зардал үйл ажиллагааны зардалд орно.	-		Хог хаягдлын тухай хууль
Дүн:			0.5		

4.3.5. Болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө.

-Нөлөөллийн товч тодорхойлолт

Үер, гал түймрийн аюул, мөс цөмрөх, усанд живэх осол, эрсдэл гарах өндөр магадлалтай.

-Нөлөөлөлд өртөх объект.

Аялагч, амрагч, ажиллагсад болон жуулчны баазын объектууд шууд өртөх аюултай.

Хүснэгт 7 . Болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг жилд	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн үер, борооны усны аюул	Үерийн хамгаалалт хийх	Үер буух, борооны ус ихээр хуримтлагдан ирэх болзошгүй тайлбайнууд	0.5	Шаардлага тай үед	Гамшгаас хамгаалах тухай хууль
Галын аюул, түймрийн аюул, осол	Гал, түймрийн аюул, ослоос урьдчилан сэргийлэх бэлтгэлүүд, гал унтраах хэрэгсэлийн бэлэн, бүрэн байдал, хянах төхөөрөмжүүд, техникийн хяналт үзлэг	Жуулчны баазын шаардлагатай байршлуудад	0.5	Байнга	Галын аюулгүй байдлын тухай хууль
Мөс, цөмрөх, усанд живэх зэрэг	Амрагч, аялагчдыг усны болон мөс цөмрөх аюул, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, сурталчилгаа хийх, хэрэгжилтэд хяналт тавих	Далай хөлдөж эхлэх, хайлах хугацаанд болон салхи, шуургатай болон гэнэтийн аюул, ослын үед	0.5	Тухай бүр	Гамшгаас хамгаалах тухай хууль
Дүн:			1.5		

4.4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Төслийн “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-т жуулчны бааз, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрдэл хэсгүүдэд гарч буй өөрчлөлтүүдийг хянаж, тэдгээрийн төлөв байдлыг тодорхой хугацаа, мөчлөгүүдэд байгаль хамгаалах ажлын үр дүн, дараа дараагийн жилүүдэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх зорилгоор энэхүү хөтөлбөрт тусгасан ажлыг бүрэн хэрэгжүүлэх үүргийг жуулчны бааз, амралтын захиргаа хүлээнэ.

Хүснэгт 8. Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа, давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгж өртөг мян.₮	Нийт зардал мян.₮ жилд	Стандарт, аргачлал
Далайн усны эрүүл ахуйн шаардлага	Тус бүр 1 дээж	Далайн эрэг \4 цэгээс\	8 дугаар сард	Цэг бүрээс 1,5 литр дээж	62.5	500.0	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.MNS 4586:1998
Голын усны эрүүл ахуйн шаардлага	Тус бүр 1 дээж	Далайн эрэг \4 цэгээс\	8 дугаар сард	Цэг бүрээс 1,5 литр дээж	62.5	500.0	
Хөрс Эрүүл ахуйн шаардлага	Тус бүр 1 дээж	Амралтын газрын 4 цэгээс	8 дугаар сард	Цэг бүрээс 2 кг дээж	110.0	880.0	Хөрсний чанар. Хөрс бохир-дуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850 : 2008
Агаарын чанарын ерөнхий шаардлага	1 дээж	Орчны цэгээс	8 дугаар сард	Цэг бүрээс 1 дээж	55.0	55.0	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585: 2007
Нийт дүн:						1935.0	

5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Аялал жуулчлалын бааз нь үйл ажиллагааныхаа хүрээнд явган хүний тогтсон зам тавих, талхагдсан газруудад зүлэг тарьж ургуулах ажлыг энэ хүрээнд төлөвлөж байна. Энэ ажлын хүрээнд олон наст ургамал, зүлэгний үрийг 1.5 га талбайд тарьж талхагдсан газрыг зүлэгжүүлэх бөгөөд 1.5 сая төгрөгийг энэхүү арга хэмжээнд зарцуулахаар төсөвлөв.

6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

БОНХЯ-ны сайдын 2014.04.10 ны өдрийн А-117 дугаар тушаалаар баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд газрын тос олборлох, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн, нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг гаргана гэж заасан байна. Тиймээс дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг тус төслийн хувьд боловсруулах шаардлагагүй гэж үзэж байна.

7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Энэхүү аялал жуулчлалын баазын талбайтай давхцалтай нүүлгэн шилжүүлэх өвөлжөө, хаваржаа, бусад объект байхгүй бөгөөд зэлүүд газар нутаг юм. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор төлөвлөгөө боловсруулаагүй болно.

8. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Аялал жуулчлалын баазын талбай орчимд аливаа түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй бөгөөд хэрвээ олдвор олдвол Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр хамгаалалтад авч, холбогдох газарт мэдэгдэнэ.

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал Мян.төг	Хэрэгжүүлэх давтамж
Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хээрийн түймэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, анхааруулга, санамж өгч байх	Ажилчид, амрагч, аялагчид	200.0	Хавар, намрын улиралд өдөр бүр
Байгаль орчинг хамгаалах талаарх ухуулга сурталчилгааг хийх, энэ талаарх мэдээллийн самбарыг дадлагын баазад байршуулах	Ажилчид, амрагч, аялагчид	100.0	Дадлага ажил эхлэхээс өмнө
Төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг цаг тухай бүрд нь даган мөрдөх;	Аялал жуулчлалын бааз	Төлөвлөгөөнд тусгасан зардал	Үйл ажиллагааны туршид тогтмол
Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, хүчтэй шуурга)-ийн явцад амрагчид, ажилчид гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж сургаж дадлагажуулах, эмнэлгийн анхан тусламжийн хайрцгийг баазад байрлуулах	Аялал жуулчлалын бааз	300.0	4-р сард
Ханх сумын захиргаатай хог тээвэрлэн нэгдсэн цэгт хаях гэрээ байгуулах, сард 1 удаа хогийг тээвэрлүүлэн нэгдсэн хогийн цэгт хаях	Аялал жуулчлалын бааз	300.0	Жилдээ
Баазын талбайн ойр орчимд тогтсон нэг замаар зорчих, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, төслийн талбайн ойр орчимд цэвэрлэгээний ажлыг байнга хийж гүйцэтгэх	Аялал жуулчлалын бааз	Зардал шаардахгүй	Үйл ажиллагааны туршид тогтмол
БОАЖЯ, Хөвсгөл аймгийн БОАЖГ, Ханх сумын БОХУБ, байгаль хамгаалагч, Хөвсгөл нуурын БЦГ-ын хамгаалалтын захиргаа зэрэг газруудад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаарх тайлан, бусад мэдээг хүргүүлэх	Аялал жуулчлалын бааз	250.0	Тухай бүр
Нийт зардал		1150.0	

11.Тухайн жилийн байгаль орчны менежметийн төлөвлөгөө, хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь,

Хүснэгт 10. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлаг-нах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан /ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	-БОАЖЯам, -Хөвсгөл аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар, -Ханх сумын БОХУБ	Хэвлэмэл тайлан	-2025 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, мэдээнүүд.	11-р сарын 01 дотор,	Шаар-дахгүй	Гүйцэтгэх захирал	-
2.	- БОАЖЯам, -Хөвсгөл аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар, -Ханх сумын БОХУБ	Батлагдсан хэвлэмэл тайлан.	-2025 оны БОМТөлөвлөгөө хянуулж батлуулан, холбогдох газруудад хүргүүлэх. -Шинээр батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэх нөхөн сэргээлт, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хуулийн хугацаанд	Шаар-дахгүй	-Байгаль орчны ажилтан	-
3.	Хөвсгөл аймгийн Ханх сумын ИТХурал, багийн ИНХ, иргэд	Илтгэл, брошур	-Тухайн жилийн батлагдсан БОМТ-ний зорилго, хэмжээ, хэрэгжүүлэх чиглэл	6, 10 дугаар сард	400,000	-Үйл ажиллагааны менежер	-Багийн байр
	Нийт				400,000		

11. Зөвлөмжүүд.

11.1. Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах зөвлөмж

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын бааз төслийн үйл ажиллагааны явцад хэрэгжүүлэх шаардлагатай дараах зөвлөмжүүд гарсан ба БОМТ болон үйл ажиллагааны явцад мөрдөн ажиллана. Тус төслийг хэрэгжүүлэхдээ MNS 6426:2013 “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр, сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартыг даган мөрдөж ажиллана. Үүнд:

- Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээнд заасан нөхцөл, эрх үүргийн дагуу үйл ажиллагаа явуулж, зориулалтын дагуу ашиглана.
- Нийтийн үйлчилгээний зам талбайг байгалийн материалаар засч тохижуулсан байна.
- Эдэлбэр газрын нийт талбайн 20-с багагүй хувьд ногоон байгууламжтай, хөл газрын ургамалгүй байна.
- Эдэлбэр газарт баригдах барилга, байгууламж нь зөвшөөрөл бүхий газрын хил, зааг дотор байна.
- Тээврийн хэрэгслийн (авто) зогсоолыг байр, сууц, байгууламжаас 200м-ээс багагүй зайд байрлуулах ба тээврийн хэрэгслийн зогсоол нь MNS 5342:2007 стандартын шаардлагыг хангасан байна.
- Байр сууц, байгууламж нь аялал жуулчлалын бүтээгдэхүүний үндсэн шинж чанарыг хадгалсан, тухайн орчны байгаль ландшафтын дүр төрхөд нийсэн, түүхийн соёлын өвийг хүндэтгэсэн хийц, загвартай байх ба барилгын газар дээрх давхар хоёр (2) давхраас өндөргүй байна.
- Эрчим хүчний хэрэглээний 30-аас багагүй хувийг сэргээгдэх буюу нар, салхины эрчим хүчээр хангана.
- Хог хаягдал хадгалах зориулалтын цэгийг байр сууц, хоолны газраас 60м-с багагүй зайд бие засах газраас тусад нь зонхилох доод зүгт байрлуулж, салхинд хийсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн, хөрсөнд шингэхээс хамгаалсан байна.

11.2. “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулийн дагуу дараах зүйлсийг хориглоно.

- Газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх
- Байгалийн дагалдах баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх
- Ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх

- Хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөргөөр нөлөөлөх арга, техник бодис хэрэглэх
- Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаас бусдаар ашиглах

11.3. Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн нуур, усан сангийн эргээс 200 метрээс доошгүй зайтай газарт тогтоох бөгөөд энгийн хамгаалалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Мод бут огтлох;
- Хаягдал бохир усыг цэвэршүүлэх байгууламжгүй буюу ариутгах татуургад холбогдоогүй барилга байгууламж барьж ашиглах;
- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис хадгалах, агуулах;
- Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;
- Хог хаягдал, бохирдуулах бодис хаях, хог хаягдлын цэг байршуулах;
- Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;
- Мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах
- Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах.

-----ooOoo-----

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

№	Материал	Хуудас
1	Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ	1
2	УТХГН-т газар ашиглах гэрээ	6
3		
4		
	Нийт	